ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 08 өдөр Дугаар А/299 Улаанбаатар хот

Нийгмийн баталгааг хангах
хөтөлбөрийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.8.11 дэх заалт, "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-нд 2025-2027 онд хэрэгжүүлэх хамтын гэрээ, "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн Захирлын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 04/02 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК болон салбар, нэгжийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хавсралтаар батлагдсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган батлуулахыг Санхүүгийн удирдлагын газар (С.Өлзийбүрэн)-т, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэхийг Захиргаа удирдлагын газар (Д.Рэнцэнбямба)-т, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлагад танилцуулахыг Дотоод аудитын газар (Э.Нарантунгалаг)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү хариуцсан ерөнхий менежер (Н.Золжаргал)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ОТГОНСҮХ

УЛААНБААТАР ХОТ
9025041227
ХТҮ9940 ф 7144857

1725 04 2076

“Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн
гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 08-ны
өдрийн А/299 дүгээр тушаалын хавсралт

“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК БОЛОН САЛБАР, НЭГЖИЙН АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Үндэслэл, хэрэгцээ шаардлага:

Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/290 дүгээр тушаалаар “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн зохион байгуулалтын бүтцийг баталсан. Байгууллагын зүгээс ажилтны нийгмийн баталгааг хангах /цалин хөлс, тэтгэмж, тусламж, нөхөх төлбөрийг олгох, тэдгээрийг нэмэгдүүлэх, шагнаж урамшуулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, эрүүл мэндийг хамгаалах, ажил болон амралтын цагийг зөв, үр бүтээлтэй ашиглах, ажиллах идэвх санаачилгыг нэмэгдүүлэх, орон сууцны асуудлыг шийдвэрлэх, ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх/-тай холбогдсон шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийг баримтална.

Тус байгууллагад 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2018 ажилтан ажиллаж байгаагаас боловсролын байдлаар нь ангилбал докторын зэрэгтэй 2, магистрын зэрэгтэй 235, бакалавр 1275, дипломын дээд 20, тусгай дунд 198, бүрэн дунд 258, бүрэн бус дунд боловсролтой 30 ажилтан байна.

Нийт ажилтнуудыг насны хувьд авч үзвэл 18-30 насны 244, 31-40 насны 780, 41-50 насны 625, 51-60 насны 361, 61-ээс дээш насны 8 ажилтан байгаагаас 1246 нь эрэгтэй 772 нь эмэгтэй ажилтан байна.

Иргэний нисэхийн салбарт ажилласан жилээр нь ангилбал 5 хүртэл жил ажилласан 688, 6-10 жил ажилласан 369, 11-15 жил ажилласан 315, 16-20 жил ажилласан 312, 21-25 жил ажилласан 161, 26-аас дээш жил ажилласан 173 ажилтан байна.Ажилтнуудын 344 нь галлагаатай байшинд, 88 нь гэрт, 1596 нь орон сууцанд амьдарч байна. Орон сууцанд амьдардаг ажилтнуудын 636 нь өөрийн өмчлөлийн, 528 нь зээлийн, 277 нь бусдын өмчлөлийн орон сууцанд, 155 нь түрээсийн орон сууцанд тус тус амьдарч байна.

Мөн бусад агаарын тээвэрлэгчдийн нарийн мэргэжлийн ажилтнуудын цалин хөлсийг манай байгууллагын ажилтнуудын цалин хөлс, тусламж дэмжлэгтэй харьцуулан үзэхэд илүү байгаа нь ажилтнууд бусад байгууллагын ижил төрлийн ажилд шилжин ажиллах нөхцөлийг бий болгоод байна.

Иймд салбарын хэмжээнд нийт ажилтнууд болон тэр дундаа нарийн мэргэжлийн хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, идэвх санаачилгыг өрнүүлэх, идэвхжүүлэх зорилгоор тэдний гүйцэтгэж байгаа ажил үүрэг, ур чадварт нийцсэн цалин хөлс, урамшууллын тогтолцоо, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх, мөн ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, тусламж, дэмжлэг үзүүлэх зэрэг тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд “Ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг зайлшгүй батлуулах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1.Энэхүү хөтөлбөрийн зорилго нь ажилтны ажиллах урам зориг, хүсэл эрмэлзлийг бий болгох, ажилдаа сэтгэл ханамжтай байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн урамшууллын олон талт үйл ажиллагааг тодорхойлж хэрэгжүүлэх замаар ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дээшлүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1.Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1.Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж тэдний гүйцэтгэж байгаа ажил үүрэг, ур чадварт нийцсэн цалин хөлс, урамшуулал олгох тогтолцоог бүрдүүлэх;

3.1.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах;

3.1.3.Ажилтнуудыг амьдралын нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх;

3.1.4.Ажлын байрны орчин, нөхцөл хангамжийг сайжруулах;

3.1.5.Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх;

3.1.6.Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, ажилтнуудын сурч, хөгжих боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх;

3.1.7.Ажилтны гэр бүлийн хөгжлийг дэмжих.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

4.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

4.1.1.Хууль тогтоомжийн хүрээнд ажиллах;

4.1.2.Үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх;

4.1.3.Байгууллага хамт олны эрмэлзэл, санаачилгыг дэмжих;

4.1.4.Нөөц бололцоог бүрэн ашиглах.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1.Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж тэдний гүйцэтгэж байгаа ажил үүрэг ур чадварт нийцсэн цалин хөлс, урамшуулал олгох тогтолцоог бүрдүүлнэ.

5.1.1.Улс орны эдийн засгийн байдал, үнийн өсөлт, байгууллагын санхүүгийн нөхцөл байдалтай уялдуулан цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлэх;

5.1.2.Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулан цалингийн сүлжээний түвшинг ахиулах, урамшуулал олгох;

5.1.3.Ажлын байрны чиг үүргийг оновчтой тодорхойлох, ачааллыг жигдрүүлэх арга хэмжээ авах;

5.1.4.Нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, хөнгөлөлт, тэтгэмж, тусламжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох.

5.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулна.

5.2.1.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн шаардлагыг байгууллагын үйл ажиллагаанд хэвшүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах.

5.2.2.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн сургалтыг нийт ажилтнуудад жил бүр тогтмол зохион байгуулах.

5.2.3. Хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслээр хангах албан тушаалтнуудын жагсаалт, эдэлгээний норм, нормативыг тогтоож, тушаалаар баталгаажуулж, мөрдүүлж ажиллах.

5.2.4. Хөдөлмөрийн хэвийн бус ажлын байрыг хэвийн болгох чиглэлээр аргах хэмжээ авч ажиллах.

5.2.5. Эрсдэлтэй ажлын байрны жагсаалтыг тогтмол шинэчлэн тухай бүр холбогдох арга хэмжээг авч ажиллах.

5.3.Ажилтнуудыг орон сууцаар хангах, амьдрах нөхцөлийг сайжруулна.

5.3.1.Орон сууцны үнийн хөнгөлөлтийн хэмжээг санхүүгийн нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэх.

5.3.2.Ажилтнуудыг амьдрах орчин нөхцөлөө сайжруулах, орон сууц, хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцөлийг нь сайжруулахад хууль тогтоомжийн дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

5.4.Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулна.

5.4.1.Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан тухайн албан тушаалд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслээр хангах.

5.4.2.Дэвшилтэд шинэ тоног төхөөрөмж, технологийг ажил албандаа нэвтрүүлэх, цаасгүй технологи бий болгох, шинэ арга барилыг хэрэгжүүлэх.

5.4.3.Ажилтнуудын үдийн амралтын үеэр богино хугацаанд алжаал тайлах /цай, кофе уух, сонин сэтгүүл унших гэх мэт/ амрах өрөө тасалгааг бий болгох.

5.4.4.Ажлын байрны тохижилт, шинэчлэлтийг орчин үеийн стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

5.5.Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлнэ.

5.5.1.Эмнэлгийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж, ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах.

5.5.2.Нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ хийлгэх, эмчлүүлэх шаардлагатай ажилтнуудыг тухай бүрд нь эмчилгээ, сувилгаа болон витаминжуулалтад хамруулах зэргээр эрүүл мэндээ хамгаалахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх.

5.5.3.Эмнэлгийн нэг өрөөг тохижуулж ажилтнуудад эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх эмчийг ажиллуулах.

5.5.4.Ажилтнуудыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, спорт заалаар үйлчлэх, тогтмол иог, усан бассейнд явуулах зэрэг төрөл бүрийн спортын арга хэмжээнд хамруулж, байгууллагын спорт, биеийн тамирын арга хэмжээг тогтмолжуулах.

5.5.6."Эрүүл агаар эм" сэдэвт идэвхтэй амралт, явган болон тойрон аяллыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах.

5.5.7.Ажилтнуудад эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх ёсны мэдлэг боловсрол олгох сургалт зохион байгуулах.

5.6.Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, ажилтнуудын сурч, хөгжих боломжийг бүрдүүлнэ.

5.6.1.Ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах чиглэлээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг баталж, түүнд шаардагдах зардлыг байгууллагын жил бүрийн төсөвт тусгаж хэрэгжүүлэх.

5.6.2.Ажилтнуудад гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх, боловсрол олгоход анхаарч, байгууллагаас зохих дэмжлэг үзүүлэх.

5.6.3.Иргэний нисэхийн салбарт үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран ажилтнуудын ажил мэргэжлийн чиглэлээрх сонирхлын бүлгүүдийг бий болгох.

5.7.Ажилтны гэр бүлийн хөгжлийг дэмжинэ.

5.7.1.Шинээр гэр бүл болж байгаа болон залуу гэр бүлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

5.7.2.Ажилтнуудын бага насны хүүхдүүдийн цэцэрлэгийн асуудлыг шийдвэрлэх.

5.7.3.Ажилтны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг гаргаж, хүүхдээ асарч, сувилахад нь зориулж, нэмж тусламж олгох.

5.7.4.Ажилтнуудын гэр бүлийн гишүүдийг байгууллагын спорт цогцолборын үйлчилгээнүүдэд хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх боломжоор хангана.

5.7.5.Байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-өөс ажилтнуудын хүүхдүүд рүү чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулж ажиллана.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

6.1. Хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

6.2.Санхүү хариуцсан нэгж нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган батлуулна.

Долоо. Хөтөлбөрийн зохион байгуулалт

7.1.Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.

7.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар байгууллагын удирдлага, ажилтнууд тодорхой санал, хүсэлт гаргаж болох ба хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүн, ажилтны санал хүсэлтийг үндэслэн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.3.Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг удирдлагад танилцуулна.

Найм. Хөтөлбөрийн үр дүн

8.1.Ажилтнуудын сэтгэл ханамж дээшилж, ажлын гүйцэтгэл үзүүлэлт сайжирна.

8.2.Ажилтнууд холбогдох хууль, тогтоомжоор олгогдсон нийгмийн баталгаагаар хангагдана.

8.3.Ажилтны амьдрал ахуй, орон байрны асуудал сайжирна.

8.4.Ажилтны цалин хангамж, төлбөрийн чадвар нэмэгдэнэ.

8.5.Ажилтны тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл сайжирна.

8.6.Энэхүү хөтөлбөр болон хөтөлбөрийн төлөвлөгөө нь дараагийн хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, суурь судалгаа болно.

--------oOo-------